

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХҮЙС ТОЛГОЙН 11 ДҮГЭЭР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН
НАСАНЖАРГАЛЫН БОЛОРТУАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Хүрэх түвшин | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Жилийн эцсийн хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь | |
|--|--|--|--------------|----------------------------|---|--------------------------|--------------------------|-----------------|--------|
| | | | | | Хүрсэн түвшин (биелэлт) | | | | |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | | |
| Зорилт 1. "Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах" | | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 "Халамжаас хөдөлмөрт бэлтгэх" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах | 1.1.1. Орлого нэмэгдсэн өрхийн тоогоор | 100 | 100 | Хүнсний эрхийн бичигт нийт 76 өрх хамрагдаж байгаагаас "Халамжаас хөдөлмөрт бэлтгэх" хөтөлбөрийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 11 өрхийг хүнсний эрхийн бичгээс түдгэлзүүлэн ажилласан. Энэ онд 65 өрх буюу 140 иргэн, хүүхэд 76 нийт 216 иргэн хүнсний эрхийн бичигт хамрагдаж байна. Нийт орлого нэмэгдсэн 11 өрх байна. | 100 | 2024.01.16 2024.11.25 | 80 | 100 |
| | | 1.1.2. Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд хамрагдсан иргэний тоогоор | 17 | 23 | XXUGазар, Бэст инноваци сургалтын төвтэй хамтран эмэгтэйчүүдийг дэмжих бэлтгэх хуудалдааны зөвлөхийн гэрчилгээ олгох сургалтад 4 иргэн хамрагдсан. Халамжаас хөдөлмөрт бэлтгэх сургалт зөвлөгөөнд 15 иргэн хамрагдсан. Багийн иргэдийг халамжаас хөдөлмөрт бэлтгэх чиглэлээр ажил хайгч 10 иргэнд сургалт зохион байгуулан ажилд холбон зуучлан ажилласан. <i>f. Zeeben</i> | 23 | 2024.01.16 2024.11.25 | 100 | 65/100 |
| 2. | Арга хэмжээ 1.2 Багийн иргэдийн | 1.2.1. Мэргэжлийн чиг баримжаа олгох | 60 | 80 | Халамжаас мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 10 иргэн хамрагдсан. | 2024.01.16 2024.11.25 | 100 | 100 | |

32,6
15
15
58

222

| | | | | | | |
|---|--|-----|-----|---|--------------------------|-----|
| хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж, хөдөлмөр эрхлээгүй иргэдийг сургалтад хамруулах, ажилд зуучлах | болон амьдрах ухааны сургалтад хамрагдсан иргэний хувиар | | | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас зохион байгуулсан мэргэжил олгох худалдагч 7, тогооч 6, усчин 3, гар урлал 5 хамрагдан 14 хоногийн сургалтад суун мэргэжлийн үнэмлэхтэй болсон. ХХХҮГ-аас зарлагдсан төсөл хөтөлбөрт оролцсон 6 иргэн төсөл бичих талаар сургалтад хамрагдсан. Өвөрхангай аймаг дахь Политехник Коллежид 9-р анги төгссөн 35 хүүхэд, 20 иргэн мэргэжил олгох сургалтад хамрагдаж байна. Зорилтот бүлгийн иргэдэд "Цахим ур чадвар олгох сургалтад 5 иргэн хамруулсан. | | |
| | 1.2.2.Байнгын ажлын байранд зуучилсан иргэдийн тоогоор | 8 | 11 | Жилийн эцсийн байдлаар байнгын ажлын байранд 15 иргэн зуучилсан. Үүнд: Байнгын ажлын байранд барилгын инженер 2, барилгын туслах 6, үйлчлэгч 2, угаагч 2, худалдагч 2, галч 1 гэх мэт зуучлан оруулсан. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| | 1.2.3.Түр ажлын болон улиралын чанартай ажлын байранд зуучилсан иргэдийн тоогоор | 20 | 22 | Жилийн эцсийн байдлаар түр ажлын байранд 24 иргэн зуучилсан. Үүнд мод тарих 4, сэг зэмийн устгалд 2, барилгын туслах 5, барилгын арматур 3, ногоо суулгах 3, хог цэвэрлэгээнд 7 иргэн гэх мэт зуучлан оруулсан. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 3. Арга хэмжээ 1.3 Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 1.3.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар | 90 | 100 | Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөр хэрэгжээгүй байгаа. Хөтөлбөрт хамрагддаг 24 өрх бүх арга хэмжээнд идэвх оролцоотой оролцдог. Өрхүүдийг холбогдох газар нь холбон зуучлан ажиллаж байна. Түр ажилд 10, байнгын ажилд 2 иргэн нийт 12 иргэн зуучлан ажиллаж байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 4. Арга хэмжээ 1.4 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн | 1.4.1.Судалгаа мэдээллийн санд баяжилт хийсэн | 103 | 20 | Жилийн эцсийн байдлаар хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд судалгаанд хамрагдсан байдлаар нийт 138 иргэн үүнээс | 2024.01.16 2024.11.25 | 100 |

| | | | | | |
|--|--|------------------------|-----------|----------------------------------|------------|
| | <p>нийгмийн даатгалын бүртгэл мэдээллийн санд баяжилт хийх</p> | <p>иргэний тоогоор</p> | | | |
| <p>5. Арга хэмжээ 1.5 Ахмад нийгмийн оролцоог хангах</p> | <p>1.5.1. Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор</p> | <p>2</p> | <p>3</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |
| | <p>1.5.2. Эрүүл мэндийн шинжилгээнд хамруулсан хувиар</p> | <p>75</p> | <p>90</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |

сайн дурын нийгмийн даатгалд 84 иргэн хамрагддаг. Багийн иргэдээс хувиараа хөдөлмөр эрхэлдэг 35 иргэн нэмэгдсэн. Нийгмийн даатгалд хамрагддаггүй 31 иргэн байна. Нийгмийн даатгалд хамрагддаггүй иргэдэд нийгмийн даатгалын шимтгэлийн шинээр хэрэгжиж буй хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч цаашид төлж байхыг зөвлөсөн.

Ахмадын баясах өдөр арга хэмжээнд 11 дүгээр багаас зохион байгуулсан арга хэмжээнд нийт 13 багийн 180 ахмадуудыг хамруулан ажиллаж байна. Бие бялдрын сорилд 40 ахмад настан хамруулсан. Хангайн бүсийн ахмадын чуулга уулзалтад 15 ахмад настан оролцсон. Багийн Ажлын алба, ахмадын зөвлөлтэй хамтран Баян түмэн амралтын газар ахмадын өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан 152 ахмад настан хамрагдсан. Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан "Эрүүл урт наслахын төлөө" өдөрлөгт 10 ахмад настан хамрагдсан.

"Нарны Дөш" ӨЭМТөвтэй хамтран 11 дүгээр багийн асаргаанд байдаг ахмадуудад урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд 12 ахмад настан хамруулсан.

"Нарны дөш" ӨЭМТөвтэй хамтран 50-74 насны ахмадуудыг "Артерийн даралтыг үзэн анхан шатны үзлэгт 86 иргэн хамруулсан. Орос улсын эрүүл мэндийн бүтээгдэхүүн эм жорын сургалтад 30 ахмад настан оролцсон.

Handwritten signature

Handwritten signature

| | | | | | | | | | |
|----|---|----|----|----|---|--|--------------------------|-----|--|
| | | | | | Улаанбаатар хотоос үе мөч тулай болон бусад төрлийн үзлэгт 40 ахмад настан хамрагдсан. Нарны дөш ӨЭМТөвд анхан шатны үзлэгт 200 ахмад настан хамрагдсан. Нийт 90 хувь хамруулсан. | | | | |
| | 1.5.3.Соёл, урлаг, спорт, бусад арга хэмжээнд хамруулсан хувиар | 70 | 80 | | Угийн бичгийн сургалтад 40 ахмад настан хамрагдсан. Шугаман бүжиг дасгал хөдөлгөөний сургалтад 20 ахмад настан оролцсон. Бүх нийтийн соёл урлагийн боловсролын өдрүүд арга хэмжээ 20 ахмад настан хамрагдсан. Хийн дасгалд 10 ахмад настан хамрагдсан. | | 2024.01.16 2024.11.25 | 100 | |
| | 1.5.4.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан ахмадын хувиар | | | | Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 2 ахмад настан хамрагдсан. Өгөөмөр сувилалд 29 ахмад настан хэвтэн эмчлүүлсэн. Улаан загалмайн өдрийн үйлчилгээнд 7 ахмад настан хамрагдсан. | | 2024.01.16 2024.11.25 | 100 | |
| | 1.6.1.Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 3 | 90 | Ахмад настны хөнгөлөлттэй амрах рашаан сувиллын хөнгөлөлтөд 47 иргэн хамрагдсан. Хөдөлмөр халамжийн Үйлчилгээний газраас хөнгөлөлттэй захиалдаг тусгай хэрэгсэлд 75 иргэн хамрагдсан. Хужирт рашаан сувилалд 10 ахмад урилгаар үнэгүй амарсан. | | | | |
| 6. | Арга хэмжээ 1.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах | | | | Хараагүйчүүдийн холбооноос зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлэгт 3 иргэн хамрагдсан. Эх дэлхий элгэн нутаг зорилтот бүлгийн байгаль хамгааллын өдөрлөгийн зохион байгуулсан өдөрлөг багийн 10 иргэнийг хамруулсан. | | 2024.01.16 2024.11.25 | 100 | |

| | | | | | | | | |
|---|-----|--|-----------|--|--|---|--|-----|
| | | Хөгжлийн бэрхшээлтэй сонгуулийн боловсрол олгох сургалтад 10 иргэн хамруулсан. | | | | | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 1.6.2. Соёл урлаг, спорт, бусад арга хэмжээнд хамруулсан хувиар | 80 | 90 | <i>54</i> | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол олгох сургалтад 10 иргэн хамруулсан. | 99 сарнай арга хэмжээнд 10 иргэн хамруулсан. | Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан "Урлагийн наадамд 1 иргэн оролцсон. | Багийн ХБИргэдийн дунд зохион байгуулсан дартс, теннис, хөгжөөнт тэмцээнд багийн 2 иргэн байр эзэлсэн. | 100 |
| 1.6.3. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан иргэдийн хувь | 70 | 100 | | Төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй болон хүүхдээ асарч буй 3 иргэн хамрагдсан. | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас 45 иргэнд тусгай хэрэгсэл олгосон. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс унааны зардал 12, амралт сувилалд 15 иргэн хамруулсан. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 1.6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувиар | 80 | 90 | <i>12</i> | Багт хөгжлийн бэрхшээлтэй нийт 19 хүүхэд байдаг. Үүнээс сургуулийн насны сурдаг 6, цэцэрлэгт хамрагддаг 1 хүүхэд байна. | Сургуульд хамрагддаггүй 1 хүүхэд, цэцэрлэгт хамрагддаггүй 2 хүүхэд байна. | Энэ хүүхдүүд нь саажилт, оюуны хүнд хомсдол оноштой байнгын асаргаанд байдаг учраас сурч чаддаггүй. Цаашид сурах ямарч боломжгүй. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 7. Арга хэмжээ 1.7 Багийн хамгааллын хамтарсан үйл тогтвортой байдлыг | 100 | 100 | | Жилийн эцсийн байдлаар "Хүүхэд хамгааллын хамтарсан баг"-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөг 16 арга хэмжээний хүрээнд гарган багийн Засаг даргаар батлуулсан. Хамтарсан баг 7 удаа хуралдаж эхний хуралдаанаар төлөвлөгөөний танилцуулга хийн нууцын гэрээ байгуулж ажиллаж байна. | | | 2024.01.16 2024.11.25 | 100 |

Мөн б. бэрхшээл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь

| | | | | | | | |
|---|--|----------------|----|-----|--|--------------------------|-----|
| хангаж, үр дүнд хүрэх | 1.7.2. Үр хаасан хувиар 19. | дүнтэй кейсийн | 80 | 100 | Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон хүүхдийн утас 108 утсанд хандсан дуудлагын дагуу 11 кейс, илрүүлсэн кейс 8, нийт 19 кейс дээр ажиллаж нөхцөл байдлын үнэлгээ хийн, хүүхдэд эрсдэлийн үнэлгээ хийн ажилласан. Хаасан 19 кейс байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 8. Арга хэмжээ 1.8 Гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 1.7.3. Хүүхдийн эрсдэлийн мэдээллийн баяжилт тоогоор | санд хийсэн | 85 | 90 | Эрсдэлтэй 15 айл өрхийн судалгааг гарган, айл өрхөөр явж нөхцөл байдлын үнэлгээ нийн эрсдэлт өндөр хүүхэд, иргэнийг илрүүлэн кейс нээн ажиллаж байна. Эрсдэлт өндөр 15 хүүхдийг эрсдэлийн мэдээллийн санд оруулсан. Хүүхдүүдийг холбогдох байгууллага аж ахуй нэгжид холбон зуучлан ажилласан. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 11 гомдол ирж кейс нээн программд оруулан хаасан. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 8. Арга хэмжээ 1.8 Гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 1.8.1. Залуу бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, арга хэмжээний тоогоор | | 2 | 3 | Гэр бүлийн өдрийг тохиолдуулан Миний гэр бүл, миний аз жаргал ток шоу арга хэмжээнд 1 залуу гэр бүлийг оролцуулсан. Өвөрхангай аймаг дахь Социал демократ эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан амьдрах ухааны сургалтад 15 залуучууд хамруулсан. Бүсийн залуучуудын уулзалтад нийт 6 иргэн хамруулсан. Дэлхийн зөн ОУБ-тай хамтран багийн залуу малчин 8 гэр бүлийг хүнсний тусламжид хамруулсан. Арвайхээр сумын 13 багийн нийгмийн ажилтнуудтай хамтран "Миний гэр бүлийн аз жаргал" арга хэмжээнд 2 хос оролцсон. Уг арга хэмжээний тэмцээнд С.Лутсүх эхнэрийн хамт 1-р байранд орсон. | 2024.01.16 2024.11.25 | 100 |

Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

| | | | | | | |
|--|---|----------|----------|--|----------------------------------|------------|
| <p>Арга хэмжээ 2.1</p> <p>Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг боломжит хэлбэрээр зохион байгуулах</p> | <p>2.1.1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн хувиар</p> | <p>2</p> | <p>4</p> | <p>Хөхний хорт хавдрын илрүүлэгт 82,2% умай хүзүүний эрт илрүүлэг 92% чихрийн шижин илрүүлэгт нийт 410 хүн хамрагд 406 хүн хамрагдаж 99% Артерийн гипертензийн эрт илрүүлэгт нийт-1181 хүн хамрагдахаас 1100 хүн хамрагдаж эрт илрүүлгийн үзлэгийн хувь- 90%</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |
| <p>1.</p> | <p>2.1.2. Эрүүл мэндийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан арга хэмжээний тоогоор</p> | <p>2</p> | <p>4</p> | <p>Явуулын үйлчилгээ тусгай арга хэмжээний хөтөлбөрийн дагуу 4,6,10,11 дугаар, багийн Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран нийт 103 иргэнд сургалт, үзлэг оношилгоонд хамруулсан.</p> <p>"Нарны дөш" ӨЭМТөвтэй хамтран 50-74 насны ахмадуудыг "Артерийн даралт ихсэлт, үзлэгт хамруулсан.</p> <p>Багаас анхан шатны шинжилгээнд зорилтот бүлгийн 50 иргэнийг хамруулсан.</p> <p>Эрүүл мэндийн эрт илрүүлэгийн үзлэгт 103 иргэнийг хамруулсан.</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |
| | <p>2.1.3. Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоогоор</p> | <p>1</p> | <p>2</p> | <p>Хорт зуршил мансууруулах бодис хэрэглэхгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулан 40 иргэн хамрагдсан. Цахимаар мэдээлэн ажиллаж байна. Хорт зуршил мансууруулах бодис хэрэглэхгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа сургалт зохион байгуулан 15 иргэн хамрагдсан. Цахимаар мэдээлэн ажиллаж байна. Электрон тамхи түүний хор уршгийн талаар гарын авлага бэлтгэн 60 иргэнд тараасан. Архины хамааралтай 1 иргэнийг сэтгэц наркологиин тасагт 14 хоног хэвтэн эмчлүүлж архинаас</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |

| | | | | | | | | | |
|----|--|---|------------------------|--------|---|--|-----|--|--|
| | | | | | | гаргасан. Хамтарсан багаараа "Тантай хамт" явуулын арга хэмжээг зохион байгуулан дэлгүүрүүдэд электрон тамхи зарахгүй байх зөвлөмж өгч ажилласан. | | | |
| 2. | Арга хэмжээ 2.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, нийтийн биеийн тамираар хичээллэгчдийг нэмэгдүүлэх | 2.1. Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн нэмэгдүүлсэн хувиар | 2 5% 3 4 5 | 1 2 | Багийн ажлын албанаас зохион байгуулсан "Эрүүл агаар идэвхтэй хөдөлгөөн" 14 хоногийн арга хэмжээнд нийт 90 иргэн хамруулсан. Арвайхээр сумын Засаг даргын захирамжаар хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан, эрүүл амьдрал зан төлөв дадал бий болгох зорилгоор иргэдийг үнэ төлбөргүй спорт зааланд тоглуулсан. Бие бялдрын сорилд багийн 96 иргэнийг хамруулсан. Хийн дасгалд иргэдийг хамруулсан. Шугаман бүжигт иргэдийг хамруулан сургагч багшаар бэлтгэн ажиллаж байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 | | |
| 3. | Арга хэмжээ 2.3. Соёлын биет бус өв тээгчдийн судалгаанд баяжилт хийх шавь сургалтыг хөгжүүлж, өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлнэ | 2.3.1. Судалгаанд баяжилт хийсэн тоогоор 2.3.2. Соёлын биет бус өв тээгчдийг сурталчилсан арга хэмжээний тоогоор | - 1 2 | 1 2 | Урьд онд соёлын биет бус өв тээгч байхгүй. Энэ онд морин хуурч 1, хөөмий 1 иргэн байна. Морин хуурч 1 иргэн шавилан суугчаар 5 хүүхдэд заан өвлүүлж байна. Соёлын биет бус өвийг багийн иргэдэд цахимаар сурталчлан ажиллаж байна. Соёлын биет бус өвийг сурталчлан гарын авлага 50 иргэнд тараасан. Өндөр гэгээний өв соёлоос суралцахуй арга хэмжээнд иргэдийг оролцуулсан. | 2024.01.16 2024.11.25 | 100 | | |
| 4. | Арга хэмжээ 2.4 Өрхийн дунд угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх, | 2.4.1. Угийн бичиг хөтлөлтийн судалгааны санд баяжилт хийх угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог | 2 5 90 | 2 | Угийн бичиг хөтлөх аргыг иргэдэд цахим гарын авлага бэлтгэн боршур бэлдэн 65 иргэнд тараасан. Багаас угийн бичгийн ном бэлдэн 60 иргэнд тараасан. Угийн бичгээ хөтөлж байгаа 11 иргэн нэмэгдсэн. Айл өрхийн дунд "Угийн бичиг" хөтлөх ажлыг | 2024.01.16 2024.11.25 | 100 | | |

560

28.

| | | | | | | |
|--|---|-----------|------------|--|----------------------------------|------------|
| <p>сургалт арга хэмжээг оновчтой хэлбэрээр зохион байгуулах</p> | <p>нэмэгдүүлэх хувиар</p> | | | <p>цахимаар сурталчлан, гарын авлага бэлтгэн, сургалт арга хэмжээ зохион байгуулан ажилласан. Судалгааны дүнгээр багийн хэмжээнд 630 өрхөөс өнөөдрийн байдлаар 96 өрх угийн бичгийг хөтөлж байна. Угийн бичиг хөтлөлт 12.8 % тай байна.</p> | | |
| <p>Арга хэмжээ 2.5. Зорилтот жилийн ажлыг сурталчилах, зохион байгуулах</p> | <p>2.4.2. Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоогоор</p> | <p>2</p> | <p>3</p> | <p>Төв номын сантай хамтран “Угийн бичгээ хэрхэн хөтлөх тухай арга зүйн” сургалтад 15 иргэн хамрагдсан. Угийн бичиг хөтлөх аргыг иргэдэд цахимаар сурталчлан ажилласан. Багаас угийн бичгийн ном бэлдэн 60 иргэнд тараасан. Угийн бичгээ хөтөлж байгаа 30 иргэн нэмэгдсэн. Угийн бичиг хэрхэн хөтлөх вэ? Сургалт зохион байгуулан 52 иргэн хамруулсан.</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |
| <p>5. Арга хэмжээ 2.5. Зорилтот жилийн ажлыг сурталчилах, зохион байгуулах</p> | <p>2.5.1. Зорилтот жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар</p> | <p>90</p> | <p>100</p> | <p>Зорилтот жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2023 онд 42 иргэн, 2024 онд 86 иргэн цахимаар цэргийн бүртгэлд бүртгүүлсэн Урд оноос 2 дахин өссөн. ОНХСХерөнгөөр хийж гүйцэтгэх ажлын санал 2023 онд 125 иргэн, 2024 онд 177 иргэн цахимаар саналаа өгсөн байна. Урд оноос 41.6 хувиар өссөн дүнтэй байна. Нийт өрхийн 28.3 хувь цахимаар саналаа өгсөн байна. Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас 2024 оныг “Цахим шилжилтийг эрчимжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан Цахим Хөгжил Харилцаа Холбооны Яамтай хамтран “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтот жилийн нээлт, “Цахимд хэвшье -Digital First”</p> | <p>2024.01.16 2024.11.25</p> | <p>100</p> |

| | | | | | | | | | |
|----|--|---|-------|----|--|--|--------------------------|-----|--|
| | | | | | | өдөрлөгт багийн 28 иргэнээ хамруулан ажилласан. "Цахимын зөв хэрэглээ" сургалт зохион байгуулж 54 иргэн хамрагдсан. What 3 words апп-ыг сурталчлах, ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 123 иргэнд суулгуулж мэдээлэл өгч ажилласан. Зорилтод жилийн төлөвлөгөөний хүрээнд иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэх анхан шатны сургалтад хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдээд байна. | | | |
| 6. | Арга хэмжээ 2.6 Сум, багийн хэмжээнд туршлага болохуйц шинэ ажил санаачлан хэрэгжүүлэх | 2.6.1.Шинээр санаачилсан ажлын үр дүнгээр | 3 | 3 | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Иргэн таны төлөө аян" зохион байгуулан ажилласан. Эх үрсийн баярыг тохиолдуулан 50 зорилтот бүлгийн хүүхдүүдэд гарын бэлэг өгсөн. Хүүхдийг зодож шийтгэхгүйн эсрэг өдрөөр "Дээрлэлт дэлгэрэх ёсгүй арга" хэмжээ зохион байгуулсан. Хамтарсан багаараа "Тантай хамт" явуулын үйлчилгээг багийн нутаг дэвсгэр болон иргэдэд хүрч ажилласан. Багийн 13 нийгмийн ажилтан хамтраад "Миний гэр бүлийн аз жаргал" арга хэмжээг зохион байгуулсан. | 2024.01.16 2024.11.25 | 100 | |
| | Арга хэмжээ 3.1 Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг үйл ажиллагааны хөтөлбөр бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй | 3.1.1.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 100 ✓ | 50 | | Засгийн газрийн Хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймаг, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж төлөвлөгөөг хагас, жилээр гарган төсвийн шууд захирагчид хянуулж дүгнүүлсэн. | 2024.01.16 2024.11.25 | 100 | |

| | | | | | | | |
|-----------------------------------|---|--|-----|----|--|--------------------------|-----|
| уялдуулан боловсруулах, дүгнүүлэх | Арга хэмжээ 3.2 Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх | 3.2.1.Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 100 | 50 | Хүүхдийн мөнгөн тэтгэмж 1, асаргаа 11, хөдөлмөрийн чадвар алдалт сунгалт 13, малжуулах төсөл 1, тусгай хэрэгсэл 41, унааны зардал 9, онцгой мөнгөн тэтгэмжид 2 иргэн тус бүр өргөдлийг шийдвэрлэсэн. Шийдвэрлээгүй өргөдөл гомдол байхгүй. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 7. | | 3.2.2.Хугацаатай албан бичиг болон тайлан мэдээний хүргүүлсэн хувиар | - | - | Жилийн эцсийн байдлаар хугацаатай албан бичиг 22 ирсэн. Хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь гарган холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 8. | Арга хэмжээ 3.3 Статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санд баяжилт хийх | 3.3.3.Сарын ажлын мэдээний тоогоор | 12 | 12 | Сар бүр хийсэн ажлын жагсаалтыг Зохион байгуулагчид гарган өгч нэгтгүүлж хэвшсэн. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 9. | Арга хэмжээ 3.4 Ес зүйн болон ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах | 3.3.1.Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ | Ф. | Ф. | Нийгмийн эмзэг бүлгийн хүн амд чиглэсэн халамж хамгааллын бодлого хөтөлбөрт шаардлагатай тоон мэдээллийг судалгааг үнэн зөв гарган ажиллаж байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| 10. | Арга хэмжээ 3.5 Байгууллагаас зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох | 3.4.1.Иргэдээс гомдол мэдээлэл ирүүлээгүй байх | - | - | Жилийн эцсийн байдлаар ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргаагүй ажиллаж байна. Хагас жилийн байдлаар иргэдээс гомдол ирээгүй. | 2024.01.16 2024.11.25 | 100 |
| | | 3.5.1.Зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон хувиар | 5. | 5. | Байгууллагаас зохион байгуулж байгаа болон олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцон ажиллаж байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь | | |
|---|---|--|---------------------|--------------|---|---|--|--------------------------|-----------------|--------------------------|-----------------|
| | | | 3 | 4 | | Хүрсэн түвшин биелэлт | | | | 6 | |
| 1 | | 2 | 3 | 4 | | 5 | | 6 | 7 | | |
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | | | | | |
| 2.1 | Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө боловсруулна | Төлөвлөгөө боловсруулсан байна | 1 | 1 | 1 | Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Цагийн сургалтад хамрагдсан. | | 2024.01.16 2024.11.25 | 100 | | |
| 2.2 | Богино болон дунд чиглүүлэх сургалтад хамрагдах | Сэтгэлзүйн анхан шатны зөвлөгөө өгөх сургалтад хамрагдах | 1 | 1 | 1 | Арвайхээр сумын Хамтарсан баг Хөөрхөн зүрх ТББ-тай хамтран "Сэтгэцийн гэмтэлд суулцсан нийгэм-сэтгэлзүйн анхан шатны сургалтанд хамрагдсан. | | 2024.01.16 2024.11.25 | 100 | | |
| 2.3 | | Монгол бичгийг албан хэрэглээнд ашиглах | 1 | 1 | 1 | Монгол бичгийн сургалтад хамрагдсан. Анхан шатандаа хэрэглээ болгон ажиллаж байна. | | 2024.01.16 2024.11.25 | 100 | | |
| Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт | | | | | | | | | | | |
| | | | Гүйцэтгэлийн түвшин | | | | | | | | |
| Д/Д | Үүрэг даалгавар арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | | | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | "Эрчим хүчний төсөл" 2 арга хэмжээний хүрээнд | "Эрчим хүчний төсөл" 2 арга хэмжээний хүрээнд | 1 | 1 | Дэлхийн банкны санхүүжилтээр Арвайхээр сумын гэр хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэлтийн төсөл хэрэгжиж байгаатай холбогдуулан хуучин модон тулгуурыг бетон тулгуураар сольсон бөгөөд цахилгааны утсыг бүрээстэй /СИП/ утсаар солих, хуучин тоолуурыг ухаалаг тоолуураар сольж, шинэ шугамаас айлуудад | | | | | 2024.01.16 2024.11.25 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|--|--------------------------|-----|--|
| | | | | | | холболт хийх ажилд иргэдэд зар хүргэн ажилласан. | | | |
| 2 | Багийн нутаг дэвсгэрт цэвэр бохир усны шугамын ажлын хүрээнд | Айл өрхүүдэд холболт хийх | 1 | 1 | 1 | Ноёны 10 дугаар баг, Хүйс толгойн 11 дүгээр багуудад цэвэр-4,2 км, бохир-3,1 км шугам сүлжээг тус тус холбов. 2024 онд цэвэр, бохирын шугам сүлжээний ажлууд явагдаж гүйцэтгэл 30 хувьтай явагдаж байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 | |
| 3 | СЗДТГазраас зохион байгуулсан агаарын бохирдол утааг багасгах зорилготой. | Угаар мэдрэгч төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулсан. | 1 | 1 | 1 | Багийн 30 өрхд угаарын хий мэдрэгч суурилуулан хяналт тавин ажиллаж байна. Угаарын хий мэдрүүлэгч ашиглаж буйд хяналт тбайнга тавин ажиллаж байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 | |
| 4 | Арвайхээ сумын ГХУСэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулсан ажил | Архины гаргах | 1 | 1 | 1 | Иргэн Д.Б-г Баянхонгор аймгийн "Жаргалтай амьдрал аддитлогийн төвд хандан 14 хоногийн архины эмчилгээнд явуулсан. Одоо хяналт тавин ажиллаж байна. Архи 8 сар уугаагүй байна. | 2024.01.16 2024.11.25 | 100 | |
| 5 | Төр төрийн бус байгууллагатай хамтран ажилласан | Арвайхээр сумын ЗДТГазар, ОБГазар | | | | 1,2 дугаар улирлын БИНХурлын зарыг иргэдэд хүргэн 147 иргэн хамрагдсан. Онцгой байдлын газраас "Аюулгүй галлагаа" нэгдсэн арга хэмжээг 13 багийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээнд аюулгүй байлал хангах зөвлөгөөг 60 айл өрхөөр орж өгсөн. Бүх нийтээр мод тарих өдрүүд "Тэр бум" мод үндэсний хөдөлгөөний аяны хүрээнд мод тарьж багийн 22 иргэнд агч 1, улиас 2 ширхгийг үнэгүй өгч тариулсан. Багийн ИНХурлын 1,2,3 дугаар улирлын зарыг иргэдэд мэдээлсэн. Багийн нутаг дэвсгэрт 1,2,3 дугаар улирлын цэвэрлэгээний зарыг хүргэн цэвэрлэгээнд иргэдийг оролцуулсан. Багийн цэргийн насны залуучуудад цэргийн зарыг хүргэсэн. Орон даяар гамшгийн аюулын тухай зарлан | 2024.01.16 2024.11.25 | 100 | |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>дуудах мэдээллийн дуут дохиогоор “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрт 51 иргэнд зар хүргэн хамруулсан.</p> <p>Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Үер гол усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж, Улсын онцгой комиссын 01 дүгээр албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 6-8 сард 2 удаа дайрга, Онги, Цагаан бургас орчмоор эргүүлд гарсан.</p> | | |
|--|--|--|--|--|--|--|--|

ТАЙЛАНГАРГАСАН:



ХҮЙС ТОЛГОЙН 11 ДҮГЭЭР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН /Н.БОЛОРТУЯА

2024.11.25